



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

391.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 327	1717
392.	Журам батлах тухай	Дугаар 341	1726

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

393.	Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 04	1729
------	---	-----------	------

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр
Дугаар 327
Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Усны тухай хуулийн 9.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 2011 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 302 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр”-ийг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН
ХӨГЖЛИЙН САЙД**

С.ОЮУН



Засгийн газрын 2013 оны 327 дугаар
тогтоолын хавсралт

АШИГЛАЛТЫН ЗОРИУЛАЛТЫГ ТООЦОХ ИТГЭЛЦҮҮР

1. Гадаргын ус

№	Монгол орны усны сав газар	Хүнсний үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тугамд			Уул уурхайн үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тугамд				Ус шавхан зайлуулах	Эрчим хүчний үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоометр тугамд	Газар тариалангийн үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тугамд	Ногоон байгууламжийн ашигласан усны шоометр тугамд	Мал аж ахуйн ашигласан усны шоометр тугамд	Бусад, ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэний ашигласан усны шоометр тугамд
		Архи, пиво, согтууруулах ундаа	Ундаа, цэвэр ус	Талх, чихэр, нарийн боов, бусад	Ашигт малтмал олборлох, баяжуулах	Эсийн баяжмал, хайлгуур жонш баяжуулах	Дотоодын хэрэглээнд нийлүүлж буй нүүрсний олборлолтын шавхан зайлуулалт	Эрэл, хайгуулын өрөмдлөг хийх						
1	Сэлэнгэ мөрний сав газар	0.8	0.8	0.8	0.8	0.8	0.8	0.8	0.9	0.4	1	1	0.7	0.5
2	Хөвсгөл нуур, Эгийн голын сав газар	0.6	0.6	0.5	1	1	0.8	1	0.7	0.2	0.8	0.8	0.5	0.3
3	Шмэхэд голын сав газар	0.8	0.8	0.7	1	1.2	1	1.2	1.1	0.4	1	1	0.7	0.5



4	Дэлгэрмөрөнгийн сав газар	0.8	0.8	0.7	0.7	0.5	0.8	0.8	1	1.2	1.2	0.5	1.1	0.9	0.4	1	1	0.7	0.5
5	Идэр голын сав газар	0.9	0.9	0.8	0.8	0.6	0.8	0.8	1.1	1.3	1.3	0.6	1.2	1	0.5	1.1	1.1	0.8	0.6
6	Чулуут голын сав газар	0.9	0.9	0.8	0.8	0.6	0.8	0.8	1.1	1.3	1.3	0.6	1.2	1	0.5	1.1	1.1	0.8	0.6
7	Хануй голын сав газар	0.8	0.6	0.5	0.5	0.4	0.8	0.8	1	1.2	1.2	0.5	1.1	0.9	0.4	1	1	0.7	0.4
8	Орхон голын сав газар	0.4	0.3	0.3	0.3	0.2	0.4	0.4	0.7	0.9	0.9	0.2	0.8	0.6	0.2	0.7	0.7	0.4	0.2
9	Туул голын сав газар	0.4	0.3	0.3	0.3	0.2	0.4	0.4	0.7	0.9	0.9	0.2	0.8	0.6	0.2	0.7	0.7	0.4	0.2
10	Хараа голын сав газар	0.5	0.4	0.3	0.3	0.2	0.4	0.4	0.7	0.9	0.9	0.2	0.8	0.6	0.2	0.7	0.7	0.4	0.2
11	Ерөө голын сав газар	0.7	0.6	0.5	0.5	0.4	0.6	0.6	0.9	1.1	1.1	0.4	1	0.8	0.3	0.9	0.9	0.6	0.4
12	Онон голын сав газар	0.7	0.6	0.5	0.5	0.4	0.7	0.7	0.9	1.1	1.1	0.4	1	0.8	0.3	0.9	0.9	0.6	0.4

13	Улз голын сав газар	0.7	0.6	0.5	0.5	0.4	0.6	0.9	1.1	1.1	0.4	1	0.8	0.3	0.9	0.9	0.6	0.4
14	Хэрлэн голын сав газар	0.5	0.5	0.4	0.4	0.3	0.5	0.7	0.9	0.9	0.2	0.8	0.6	0.3	0.7	0.7	0.4	0.3
15	Буйр нуур, Халх голын сав газар	0.5	0.4	0.3	0.3	0.2	0.4	0.7	0.9	0.9	0.2	0.8	0.6	0.2	0.7	0.7	0.4	0.2
16	Мэнэнгийн талын сав газар	0.8	0.8	0.7	0.7	0.5	0.8	1	1.2	1.2	0.5	1.1	0.9	0.4	1	1	0.7	0.5
17	Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар	0.6	0.6	0.5	0.5	0.4	0.7	0.8	1.2	1.2	0.3	0.9	0.7	0.2	0.8	0.8	0.5	0.4
18	Галба-Өөш Долоодын говийн сав газар	0.6	0.6	0.5	0.5	0.4	0.7	0.8	1.2	1.2	0.3	0.9	0.7	0.2	0.8	0.8	0.5	0.4
19	Онги голын сав газар	0.4	0.4	0.4	0.4	0.3	0.5	0.7	1.2	1.2	0.2	0.8	0.6	0.1	0.7	0.7	0.4	0.3
20	Алгайн өвөр говийн сав газар	0.7	0.7	0.6	0.6	0.5	0.7	0.9	1.2	1.2	0.4	1	0.8	0.3	0.9	0.9	0.6	0.5
21	Таац голын сав газар	0.7	0.7	0.6	0.6	0.5	0.7	0.9	1.2	1.2	0.4	1	0.8	0.3	0.9	0.9	0.6	0.5

22	Орог нуур, Түйн голын сав газар	0.7	0.6	0.5	0.5	0.4	0.7	0.9	1.2	1.2	0.4	1	0.8	0.3	0.9	0.9	0.6	0.4
23	Бөөнцагаан нуур, Байдраг голын сав газар	0.7	0.6	0.5	0.5	0.4	0.7	0.9	1.1	1.1	0.4	1	0.8	0.3	0.9	0.9	0.6	0.4
24	Хяргас нуур, Завхан голын сав газар	0.6	0.5	0.5	0.5	0.3	0.7	0.9	1	1	0.4	1	0.7	0.3	0.9	0.9	0.6	0.3
25	Хүйсийн говь, Цэцэг нуурын сав газар	0.7	0.7	0.6	0.6	0.4	0.7	0.9	1.2	1.2	0.4	1	0.8	0.3	0.9	0.9	0.6	0.4
26	Үенч Бодонч голын сав газар	1	1	1	1	0.7	0.9	1.4	1.2	1.2	0.9	1.5	1.3	0.4	1.4	1.4	1.1	0.7
27	Булган голын сав газар	1	1	1	1	0.7	0.9	1.4	1.2	1.2	0.9	1.5	1.3	0.4	1.4	1.4	1.1	0.7
28	Хар нуур, Ховд голын сав газар	0.5	0.5	0.4	0.4	0.3	0.5	0.8	0.9	0.9	0.3	0.9	0.7	0.2	0.8	0.8	0.5	0.3
29	Увс нуур, Тэс голын сав газар	0.7	0.7	0.6	0.6	0.4	0.8	1	0.9	0.9	0.5	1.1	0.9	0.3	1	1	0.7	0.4



2. Газрын доорх ус

№	Монгол орны усны сав газар	Хүн амын үнд, ахуйн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд				Хүнсний үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тутамд				Уул уурхайн үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тутамд				Ус шавхан зайлуулах	Эрчим хүчний үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоометр тутамд	Газар тариалангийн үйлдвэрлэлд ашигласан усны шоометр тутамд	Ногоон байгууламжийн ашигласан усны шоометр тутамд	Мал аж ахуйн ашигласан усны шоометр тутамд	Буцаа, ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, иргэний ашигласан усны шоометр тутамд
		Архи, пиво, согтууруулах ундаа	Ундаа, цэвэр ус	Талх, чихэр, нарийн боов, бусад	Ашигт малтмал олборлох, баяжуулах	Эсийн баяжмал, хайлур жонш баяжуулах	Дотоодын хэрэгцээнд нийлүүлж буй үйлдвэрлэл	Олборлолтын шавхан зайлуулах	Эрэл, хайгуулын өрөмдөг хийх	Ашигт малтмал олборлох, баяжуулах	Эсийн баяжмал, хайлур жонш баяжуулах	Дотоодын хэрэгцээнд нийлүүлж буй үйлдвэрлэл	Олборлолтын шавхан зайлуулах						
1	Сэлэнгэ мөрний сав газар	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.1	0.2	0.18	0.7	0.13
2	Хөвсгөл нуур, Эгийн голын сав газар	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.3	0.6	0.5	0.9	0.4
3	Шилхэд голын сав газар	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.6	0.3	0.6	0.5	0.9	0.4

13	Улз голын сав газар	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	1.3	1.4	1.2	0.4	1.4	1.2	0.15	0.3	0.25	0.7	0.2
14	Хэрлэн голын сав газар	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	1.4	1.4	1.2	0.3	1.5	1.2	0.15	0.3	0.25	0.6	0.2
15	Буйр нуур, Халх голын сав газар	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4	0.4	1.9	1.6	1.4	0.5	2.1	1.4	0.2	0.4	0.35	0.6	0.25
16	Мөнхнгийн талын сав газар	0.25	0.25	0.25	0.25	0.25	0.25	0.25	0.25	0.25	1.3	1.6	1.4	0.3	1.5	1.4	0.1	0.25	0.2	0.6	0.16
17	Умард говийн Гүвээт-Халхын дундад талын сав газар	0.25	0.25	0.25	0.25	0.25	0.25	0.25	0.25	0.25	1.3	1.8	1.6	0.3	1.5	1.6	0.1	0.25	0.2	0.6	0.16
18	Галба-Өөш Долоодын говийн сав газар	0.25	0.25	0.25	0.25	0.25	0.25	0.25	0.25	0.25	1.3	1.2	1.2	0.3	1.7	1.2	0.1	0.25	0.18	0.6	0.16
19	Онги голын сав газар	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3	1.3	1.8	1.6	0.3	1.5	1.6	0.1	0.3	0.22	0.6	0.2
20	Алтайн өвөр говийн сав газар	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	0.2	1.2	1.4	1.2	0.3	1.3	1.2	0.1	0.2	0.16	0.7	0.15
21	Таац голын сав газар	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	2	2.4	2.2	0.5	2.1	2.2	0.2	0.5	0.35	0.7	0.3



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2013 оны 10 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 341

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 13.8 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Зээл тусламжаар авах болон өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн импортлоход ачилтын өмнөх хяналт, шалгалт хийх журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Д.Гүньбазар)-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

Д.ТЭРБИШДАГВА

Засгийн газрын 2013 оны 341 дүгээр
тогтоолын хавсралт

ЗЭЭЛ ТУСЛАМЖААР АВАХ БОЛОН ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ ХҮНСНИЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮН ИМПОРТЛОХОД АЧИЛТЫН ӨМНӨХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсад гадаадын зээл тусламжаар авах болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.5-д заасан өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн импортлох (цаашид “өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн” гэх) тохиолдолд ачилтын өмнөх хяналт, шалгалт хийхтэй холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсад импортлоход Дэлхийн худалдааны байгууллагын “Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хэлэлцээр” (SPS Agreement)-ийн зарчим болон экспортлогч оронтой харилцан тохиролцсон ариун цэвэр, хорио цээрийн нөхцөлийг баримтална.



Хоёр. Өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд,
бүтээгдэхүүний импорт хийхэд тавигдах шаардлага

2.1. Импортлогч хуулийн этгээд нь Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн эсхүл Монгол Улстай ариун цэвэр, хорио цээрийн нөхцөл урьдчилан тохирсон экспортлогч улсаас өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлоно.

2.2. Монгол Улсад импортлох өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний биологи, хими, физикийн бохирдлын зөвшөөрөгдөх дээд хэмжээ нь олон улсын болон Монгол Улсын стандартын үзүүлэлтээс хэтрээгүй байна.

Гурав. Мэдээлэл солилцох, эрсдэлийн үнэлгээ хийх

3.1. Хяналтын эрх бүхий байгууллага өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг импортлохтой холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, стандарт болон тэдгээрт орсон өөрчлөлтийн талаархи мэдээллийг экспортлогч улсад тухай бүр нь хүргүүлэн мэдээлж байна.

3.2. Хяналтын эрх бүхий байгууллага нь Монгол Улсад өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн экспортлогч орон, бүс нутаг болон тухайн улсын хуулийн этгээдийн үйл ажиллагаанд импортын өмнөх эрсдэлийн шинжилгээ хийж, үнэлгээг гаргана.

3.3. Экспортлогч улсад мал, амьтны гоц халдварт өвчин гарсан, ургамлын хорио цээртэй зүйл илэрсэн, хүрээлэн буй орчинд хими, физикийн бохирдол үүссэн байж болзошгүй тохиолдолд экспортлогч улсын эрх бүхий байгууллагаас дараах нэмэлт мэдээллийг авсны үндсэн дээр эрсдэлийн үнэлгээ хийнэ:

3.3.1. экспортлогч улсын мал, амьтан, ургамлын өвчин, хортон, хөрс, хүрээлэн буй орчны бохирдлын талаархи мэдээлэл, тэдгээрийн үнэн зөв, баталгаат байдал;

3.3.2. тухайн улсын экспортын хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнээс үүсч болзошгүй биологи, хими, физикийн бохирдлоос урьдчилан сэргийлэх болон эрсдэл үүссэн үед яаралтай авах арга хэмжээний тогтолцоо, импортлогч талд мэдээлэх үндэсний сүлжээний талаархи мэдээлэл;

3.3.3. тухайн улсын аж ахуйн нэгжид экспортлох эрх олгох шалгуур, бүртгэх, хянах журам;



3.3.4. тухайн улсын эрсдэлийн үнэлгээнд хамрагдаж байгаа аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл, шаардлага хангаж байгаа байдал, биологи, хими, физикийн бохирдол үүсч болзошгүй нөхцөлийн талаархи бүртгэл, мэдээлэл, түүнчлэн холбогдох байгууллагуудад мэдээлэл хүргүүлж байгаа байдал;

3.3.5. үйлдвэр нь аюулын дүн шинжилгээ болон эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоо (НАССР) нэвтрүүлсэн тухай эрх бүхий олон улсын байгууллагын батламжтай эсэх.

3.4. Эрсдэлийн үнэлгээний дүнг хяналтын эрх бүхий байгууллагын удирдлагын томилсон шинжээчдийн багаар хэлэлцүүлж дүгнэлт гаргана.

Дөрөв. Өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний импортын ачилтын өмнөх хяналт, шалгалт

4.1. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.5, 13.7-д заасан өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд шаардлагатай тохиолдолд ачилтын өмнөх хяналт, шалгалт хийж болно.

4.2. Хяналтын байгууллагын хийсэн эрсдэлийн үнэлгээний дүнг Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцэж, ачилтын өмнөх хяналт, шалгалт хийх эсэх тухай шийдвэрийг гаргана.

4.3. Ачилтын өмнөх хяналт, шалгалтыг экспортлогч улсын эрх бүхий байгууллагад хүсэлт тавьсны үндсэн дээр хамтран хийх эсхүл экспортлогч улсын эрх бүхий хөндлөнгийн байгууллагаар хийлгүүлнэ.

Тав. Импортлогч хуулийн этгээдийн эрх, үүрэг

5.1. Импортлогч хуулийн этгээд нь өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг олон улсын гэрээ, хэлэлцээр, нөхцөлийн дагуу тээвэрлүүлнэ.

5.2. Экспортлогч талын эрх бүхий байгууллагаас хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд олгосон холбогдох баримт бичгийг тээврийн хэрэгсэл нэг бүрт эх хувиар нь дагалдуулж ирүүлнэ.

5.3. Өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн импортлох явцад ямар нэг эрсдэл үүссэн бол хуулийн этгээд нь энэ тухай хяналтын эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.



Зургаа. Олон улсын тээвэр зууч, тээврийн
байгууллагын эрх, үүрэг

6.1. Олон улсын тээвэр зууч, тээврийн байгууллага нь өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг олон улсын тээврийн гэрээ, хэлэлцээр, ариун цэврийн нөхцөл, шаардлагад нийцүүлэн тээвэрлэх ажлыг зохион байгуулна.

6.2. Тээврийн байгууллага нь тухайн өндөр эрсдэлтэй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэхдээ температурын горим, битүүмжлэлийн шаардлага хангасан тусгай тоноглол бүхий тээврийн хэрэгсэл, чингэлэг ашиглана.

6.3. Монгол Улсын тээвэр зуучийн байгууллага нь экспортлогч талаас олон улсын гэрээ, хэлэлцээр, ариун цэвэр, хорио цээрийн нөхцөл болон Монгол Улсын тээвэрлэлтийн стандартыг мөрдөхийг шаардана.

Долоо. Хариуцлага

7.1. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

— **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ** —

2013 оны 11 дүгээр
сарын 13-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар
хот

**Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын
тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох
заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан
шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 14.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Цэцийн гишүүн Д.Наранчимэг даргалж, гишүүн П.Очирбат, Д.Сугар, Ц.Сарантуяа, Б.Пүрэвням /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Н.Болортунгалагийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.



Хуралдаанд өргөдөл гаргагч Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороонд оршин суугч, иргэн О.Баясгалан, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нар оролцлоо.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.1, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн зарим заалт нь Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Хуралдааны явцад мэдээлэл гаргагч иргэн О.Баясгалан Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэхийг тогтоолгох тухай шаардлагаасаа татгалзсан болно.

Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороонд оршин суугч, иргэн О.Баясгалан Үндсэн хуулийн цэцэд гаргасан мэдээлэлдээ:

“... Улсын Их Хурал нь 2012 оны 5 дугаар сарын 22-ны өдөр Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийг батлан гаргасан байх бөгөөд энэ хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар анхан шатны шүүх эрүүгийн хэрэг, эрх зүйн маргаан /цаашид “хэрэг, маргаан” гэх/-ыг анхан шатны журмаар, хамтын зарчмаар хянан шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийг оролцуулна.” мөн зүйлийн 3.3.1 дэх заалт “маргааныг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд оролцох;” мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Хэрэг, маргааныг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд нэг иргэдийн төлөөлөгч оролцуулна.” гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна.” гэж заасан болохоос иргэдийн төлөөлөгчөөр хэргийг хянан шийдвэрлүүлэн



Үндсэн хуульд заасан шүүх эрх мэдэлд халдах, шүүгчийн хараат бус байдлыг үгүйсгэх тухай зохицуулалт биш юм.

Монгол хэлний “оролцогч” гэдэг нь аливаа нэгэн үйл ажиллагаанд “оролцож байгаа этгээд” гэх утга илэрхийлэх боловч эрх мэдэлтэй гэсэн үг биш бөгөөд “хянан шийдвэрлэх” эрх бүхий этгээд гэсэн утга илэрхийлэхгүй билээ.

Аливаа хэрэг маргааны ажиллагаанд оролцогчдын тухай ойлголт нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан хэргийн оролцогчдын бүрэлдэхүүний тухай, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн гуравдугаар бүлгийн 2 дахь хэсэгт тодорхойлон заасан этгээдүүдийг хэлэх билээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй юм.” гээд

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дээрх заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.” гэсэн заалтыг зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү.” гэсэн байна.

Хоёр. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин 2013 оны 8 дугаар сарын 28-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбартаа:

“... Монгол Улсын Үндсэн хуульд хуулийн засаглал болон үндсэн хуульт ардчиллын суурь зарчмууд тусгалаа олсон билээ. Энэ хоёр зарчим хоорондоо зөрчилдөхгүйгээр орших боломжтой.

Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна.” гэжээ. Эндээс бид Үндсэн хууль иргэдийн төлөөлөгчдийг хэрхэн оролцуулахыг тогтоохыг



хууль тогтоогчдод үлдээжээ гэдгийг харж болно. Гэхдээ иргэдийн төлөөлөгчийн оролцооны хэм хэмжээ, хэлбэрийг хууль тогтоогчид ямар байдлаар тогтоох нь энэхүү маргааны асуудал болж байна.

Иргэдийн төлөөлөгчийн эрх хэмжээ, холбогдох бусад харилцааг Шүүхийн тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Эрүүгийн байцаан шийтгэх, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар тус тус зохицуулсан байдаг. Гэсэн хэдий ч практик судалгаагаар энэ нь хэлбэрийн төдий болох нь батлагдсан.

Үндсэн хууль мэдээж ийм хэлбэрийн төдий оролцох ач холбогдолгүй оролцоог зарчим болгож суулгаагүй. Энэ нь зөвхөн өмнөх хууль хэрэгжүүлэлтийн алдаа төдий биш, анхнаасаа энэ нь үр нөлөөгүй хэлбэрийн зохицуулалт байна гэдгийг харуулж байгаа юм.

Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар иргэдийн төлөөлөгчийн эрх хэмжээ, оролцох механизм, зохион байгуулалтыг нарийвчлан зохицуулсан нь иргэдийн оролцоог баталгаажуулж, Үндсэн хуулийн үзэл санааг бодит утгаар хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой зүйл билээ.

Мэдээж энэ хууль нь Үндсэн хуультай тэр дундаа өргөдөл гаргагчийн дурдсан Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгтэй зөрчилдөх ёсгүй. Дараах шалтгааны улмаас Шүүгчийн хараат бус байдлыг зөрчөөгүй гэж үзэж байна.

Харьцуулсан эрх зүй судлал бусад улс оронд нийтлэгээр шүүх ажиллагаан дахь иргэдийн оролцооны “judge” буюу тангарагтны шүүгчид, “lay judge” буюу мэргэжлийн бус шүүгч гэсэн хоёр загвар байгаа гэж үздэг. Тангарагтны шүүх нь тодорхой тооны иргэд шүүгчийн оролцоогүй хэргийг үйл баримт буюу гэм буруугийн хувьд шийдвэрлэдэг бол мэргэжлийн бус шүүгч нь мэргэжлийн шүүгч нартай хамтран гэм буруугийн болон бусад асуудлаар шийдвэр гаргахад оролцдог ялгаатай.

Иргэдийн төлөөлөгчийн оролцоо мөн мэргэжлийн боловсролгүй энгийн иргэд ч тухайн нийгэмдээ зөв буруу, шударга, шударга бусыг таньж ойлгох чадавхтай болохыг илэрхийлдэг.

Ийнхүү иргэдийн төлөөлөгчдийг шүүн таслах ажиллагаанд шийдвэр гаргах бүрэлдэхүүнд оролцуулдаг нь эдгээр улсуудын үндсэн

хуулийн зарчмууд болох шүүгчийн бие даасан байдал, шүүхийн хараат бус байдалтай зөрчилдөөгүй гэж үзсэн байдгийг илэрхийлж байна.

1990-ээд оноос өмнө манай улсад бүх шатны шүүх хэрэг, маргааныг анхан шатны журмаар шийдвэрлэхдээ нэг шүүгч, хоёр ардын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэж байв. Өөрөөр хэлбэл, ардын төлөөлөгч нь мэргэжлийн шүүгчийн адил “таслах эрх” эдэлж байсан болно.

Нөгөө талаар шүүхийн үйл ажиллагааны зарчмууд нь Монгол Улсын иргэний үндсэн эрх болох шударга шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх эрхийг хангах үндсэн зорилготой учир бид Үндсэн хуулийн дээрх хоёр зарчмыг энэ эрхийг илүү хангах талаас нь тайлбарлах нь зохистой.

Хууль ёсны (хуулиар байгуулагдсан, гагцхүү хуульд захирагддаг), шударга шүүхээр (иргэнд ойлгомжтой, төвийг сахисан, ил тод үйл ажиллагаатай) шүүлгэх иргэний үндсэн эрхийг хангахын тулд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус зарчим яригддаг.

Үндсэн хуулийн онолоор шүүх, шүүгч нь өөрөө анхдагч эх үүсвэр биш бөгөөд хүний жам ёсны эрхтэй өрсөлдөх зүйл биш. Тиймээс шүүгчийг жам ёсны мэт үнэлж, шүүгчийн хараат бус байдлыг иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхтэй сөргөлдүүлэх болон давуулж үнэлэх боломжгүй.

Тиймээс шүүхийн шүүгчийн хараат бус байдлаар хамгаалагдсан шүүгчид гагцхүү хуульд захирагдан иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг ханган ажиллаж буйг ил тод харуулан иргэдийн итгэлийг бэхжүүлэх, нөгөө талаар шүүн таслах ажиллагааг хариуцлагажуулахад чухал ач холбогдолтой шударга ёсонд нийцсэн механизм бол иргэдийн төлөөлөгчийн шүүх бүрэлдэхүүн дэх оролцоо юм.

Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан иргэдийн төлөөлөгчийн оролцоог энэ түвшинд ойлгож байж Үндсэн хуулийн суурь зарчим, зорилго болох иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангах бөгөөд энэ нь шүүгчийн хараат бус байдлын зарчимтай зөрчилдөхгүй юм. Ингэснээр шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдалд нөлөөлүүлэх гэсэн биш харин иргэдэд энэ эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцох боломж буюу Үндсэн хуульд ардчиллын зарчим хуулийн засаглалын зарчимтай хослон хэрэгжиж буйн илрэл болно.



Иймд Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн, мөн зүйлийн 3.3.1 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг нь Үндсэн хуулийн иргэдийн төлөөлөгч оролцуулах болон шударга шүүхээр шүүлгэх эрхтэй нийцэж байгаа бөгөөд шүүгчийн хараат бус байдлын зарчимтай зөрчилдөхгүй гэж үзэж байна.” гэжээ.

Гурав. Монгол Улсын Дээд шүүх Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“Тухайн асуудлыг Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчдийн бүрэлдэхүүнээр хянан хэлэлцээгүй, хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиуд шинэчлэгдэн гараагүй нөхцөлд маргаантай холбоотой ойлголтод Улсын Дээд шүүхийн тайлбар, байр суурийг тодорхойлох боломжгүй юм.

Иймээс шүүх бүрэлдэхүүн, түүнд иргэдийн төлөөлөгчдийг оролцуулах тухай асуудлаар Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, үндсэн хуулийн эрх зүйн онол, үндсэн зарчим хууль хэрэглээний арга зүйн талаас хянан үзэж маргааныг хянан шийдвэрлэх боломжтой гэж үзнэ.” гэжээ.

Дөрөв. Монгол Улсын Ерөнхий прокурор, Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх Д.Дорлигжав Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“... Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.” гэж, харин Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна.” гэж тус тус заасан.

Бидний үзэж буйгаар Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн агуулга нь шүүгчийн хараат бус байдлыг тунхаглан хамгаалсан хэм хэмжээ бөгөөд хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгчийг шүүгчид хөндлөнгөөс нөлөөлж байгаа иргэн гэж үзэх боломжгүй, шүүгчтэй хамтран шүүх эрх мэдлийн үйл ажиллагаанд оролцогч иргэн гэж үзэх



үндэстэй юм. Иргэдийн төлөөлөгчийн энэ эрх нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлд “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна.” гэж зааснаар үүсэх бөгөөд Үндсэн хуулийн хэм хэмжээнээс үзвэл иргэдийн төлөөлөгч нь хэрэг, маргааныг хянан хэлэлцэх, шийдвэрлэх бүх шатанд оролцохоор заасан байгаа нь уг зүйлийн “хамтран шийдвэрлэхдээ” гэж зааснаас тодорхой харагдаж байна.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Бүх шатны шүүх нь Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.” гэж зааснаас үзэхэд шүүхийг зөвхөн шүүгч бүрдүүлэхээр байна.

2. Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.” гэсэн нь шүүх бүрэлдэхүүнд хамааралтай байна.

3. Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна.” гэснийг иргэдийн төлөөлөгчийг шүүх бүрэлдэхүүнд оролцуулахаар заасан гэж үзэхээргүй байна.

Иймд Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.1, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн гэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨЭС ДҮГНЭЛТ ГАРГАХ НЬ:

1. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.1 дэх заалтад “маргааныг хянан шийдвэрлэх



шүүх бүрэлдэхүүнд оролцох;”, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Хэрэг, маргааныг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнд нэг иргэдийн төлөөлөгч оролцуулна.” гэж тус тус заасны “...шүүх бүрэлдэхүүнд...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.1 дэх заалтын “... шүүх бүрэлдэхүүнд ...”, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “...шүүх бүрэлдэхүүнд...” гэсэн заалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2013 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авсанаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ:

Д.НАРАНЧИМЭГ

ГИШҮҮД:

**П.ОЧИРБАТ
Д.СУГАР
Ц.САРАНТУЯА
Б.ПҮРЭВНЯМ**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn
Утас: 262420
Хэвлэлийн хуудас: 1.25
Индекс: 14003